



ПРЕМИУМ НЭКСУС ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 1

Улаанбаатар хот

Премиум Нэксус ХК ("Компани")-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал ("Хурал")-ыг 2025 оны 04-р сарын 29-ний өдрийн 11:00 цагт Монгол Улс, Улаанбаатар 14241, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж 19А, Шангри-Ла Төв, 4-р давхар, Өргөө 3 IMAX-д биечлэн болон цахимаар хуралдуулав.

Хурлын даргаар Компанийн Гүйцэтгэх захирал А.Ганхуяг, Тооллогын комиссоор Өлзий энд Ко капитал ҮЦК ХХК-ийн Брокер Ш.Түвшинбаяр (дарга), Комплайнс О.Мөнхгэрэл, Санхүүгийн шинжээч Б.Марал нар, Хурал зохион байгуулах комиссоор Гүйцэтгэх захирлын орлогч Г.Чинзориг (дарга), Санхүүгийн газрын захирал, Бизнес контроллер Д.Бүдханд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Т.Гантулга нар ажиллав.

Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын газрын захирал Г.Хасбаатар Хурлын танхимын онгой байдлын үеийн аврах гарц, цугларах цэгийн талаар зааварчилгаа өгөв.

Хурлын дарга Тооллогын комиссын даргаас хурлын ирцийг танилцуулахыг хүсэв. Хуралд Компанийн 1,017,839,370 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг хувьцаа эзэмшигчид оролцож Компанийн нийт саналын эрх бүхий 1,114,252,034 ширхэг энгийн хувьцааны 91.35 хувь болж байгааг Хуралд оролцогч хувьцаа эзэмшигчдэд болон Хурлын даргад мэдээлж Компанийн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 91.35 хувийг эзэмшигчид Хуралд оролцож байгаа тул Хурлыг хүчин төгөлдөрт тооцсоныг мэдээлэв.

1. ХУРЛЫН НЭЭЛТ

Хурлын дарга Хурлыг нээж, үг хэлэв. Компани нь 2024 онд 71 дэлгүүр шинээр нээснээр нийт 445 (19% өсөлт) дэлгүүртэй болсон бөгөөд үүнээс 49 дэлгүүр нь орон нутагт үйл ажиллагаа явуулж байна. Бид орон нутагт үйл ажиллагаагаа тэлснээр хүнсний аюулгүй байдлыг хангасан, олон улсын стандартад нийцсэн үйлчилгээг үзүүлж, соёлыг түгээж байна. Аялал жуулчлал, үйлчилгээний дэд бүтцийг сайжруулж, орон нутагт шинээр ажлын байр бий болгож, бизнес эрхлэгчдийг дэмжин ажиллаж байна. 2024 онд давтагдсан тоогоор 58.5 сая (30% өсөлт) хэрэглэгчид үйлчилж 598 тэрбум төгрөгийн (53% өсөлт) цэвэр борлуулалттай байсан байна. Премиум Нэксус ХК нь СУ төвтэй бизнесийн экосистемийг бүрдүүлэн ажиллаж байгаа нь үр дүнгээ өгч байна. Тухайлбал үр ашигтай ложистикийн системийг бүрдүүлэн өдөрт 700 мянган бараа бүтээгдэхүүн түгээснээр Улаанбаатар хотын автомашины ачааллыг 1,003 машинаар бууруулж байна. Компани нь хөдөлмөрийн аюулгүй байдал, кибер аюулгүй байдалд онцгой анхаарч ажилладаг тухай дурдаад Хурал нээснийг мэдэгдэв.

Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн дарга (хараат бус) Гари Биондо хувьцаа эзэмшигчдэд хандан үг хэлэв. Эрхэм хүндэт хөрөнгө оруулагчид аа, 2024 он бол Премиум Нэксус ХК-ийн хувьд эргэлтийн цэг байсан. Бид 2024 онд ашигт ажиллагаанд хүрсэн төдийгүй Улаанбаатар хотоос гадна хөдөө орон нутгийн зах зээлд амжилттай тэлэлт хийсэн. Энэ бол бидний бизнесийн өсөлтийг авчрах, тогтвортой бизнесийг бий болгох, компанийн хувьцаа эзэмшигчдэд оногдох үнэ цэнийг нэмэгдүүлэхийн төлөөх тууштай хичээл зүтгэлийн тод илрэл юм. Улаанбаатар хотод тэлэлт хийх явцдаа тулгарч байсан үйл ажиллагааны бэрхшээлүүдийг даван туулж, бид үндэсний түвшинд

тэргүүлэх чадвартай, илүү хүчирхэг, илүү хурдтай, уян хатан бизнесийг бий болгож чадлаа. Бид үйл ажиллагааны цар хүрээгээ нэмэгдүүлэх, тогтвортой хөгжил, сайн засаглалыг бий болгоход илүү анхаарал хандуулж, хараат бус ТУЗ-ийн даргыг томилсноор ил тод байдал, хариуцлагатай байдлыг улам бататгасан. Компанийн өсөлттэй зэрэгцэн бидний үүрэг хариуцлага ч өсөж байна. Байгаль орчин, нийгэм, сайн засаглалын санаачилгууд маань зөвхөн амлалт биш. Харин бидний үндсэн үнэт зүйл болж Монголын бизнесийн орчинд шинэ жишиг тогтоож байна. Цаашид бид үйл ажиллагаагаа улам сайжруулж, шинэ боломжуудыг нээхийн зэрэгцээ илүү их үнэ цэнийг бий болгохын төлөө хичээж ажиллах болно. Бид өнгөрсөн хугацаанд бизнесийн хувьд маш “бат бөх” үндэс суурийг бий болгож чадсан. Ирээдүйд энэ маань улам илүү хүчирхэг, бат бөх болно. Бидэнд итгэл хүлээлгэсэн та бүхэнд баярлалаа. Бид хамтдаа хэдэн жилээр хэмжигдэх бус, харин хэдэн арван жилээр хэмжигдэх эрч хүч дүүрэн, итгэл төгс ирээдүйг бүтээж байна. Энэхүү ирээдүйг бид Премиум Нексус ХК болон та бүхний төлөө бүтээж байна хэмээв.

Хурал зохион байгуулах комиссын гишүүн Д.Бүдханд Хурлын дэг, Хурлаар танилцуулах болон хэлэлцэх асуудлыг танилцуулав. Үүнд:

- (i) Компанийн 2024 оны жилийн үйл ажиллагааны тайланг танилцуулах;
- (ii) Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах;
- (iii) Компанийн 2024 оны санхүүгийн жилийн цэвэр ашиг (алдагдал)-аас ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн шийдвэр, түүний шалтгааныг танилцуулах;
- (iv) ТУЗ-ийн гишүүдийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг нь дуусгавар болгож дахин томилох.

Хуралд санал өгөх заавар бичлэг болон Компанийн үйл ажиллагааны талаарх видео бичлэгийг дэлгэцээр гаргав.

2. 2024 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Гүйцэтгэх захирлын орлогч Г.Чинзориг Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайланг танилцуулав. Компани нь 2024 онд 445 дэлгүүртэй байсан бол энэ онд 500 дэлгүүртэй, өргөн цар хүрээтэй, өдөрт 200 гаруй мянган хүнд үйлчилдэг Монголын хамгийн олон үйлчлүүлэгчтэй сүлжээ дэлгүүр болсныг дурдаад Компанийн үйл ажиллагаатай холбоотой видео танилцуулгыг үзүүлэв.

Компани нь 2024 онд ТОП 100 аж ахуйн нэгжийн 8-р байр, жижиглэн худалдааны байгууллагаас 1-р байрт орсон бөгөөд Компанийн 2024 оны цэвэр борлуулалт өмнөх оноос 45 хувиар, дэлгүүрийн тоо 19 хувиар өссөн байна. Бизнесийн цар хүрээ нэмэгдэж нийт ажиллагсдын тоо 4,677-д хүрч, нийт сүлжээний борлуулалт 89 хувиар, үйлчлүүлэгчдийн тоо 98 хувиар өссөн байна. 2024 онд 81 дэлгүүр шинээр нээж, 10 дэлгүүрийг хааж, Улаанбаатар хотод 396, орон нутагт 49 дэлгүүр, нийт 445 дэлгүүртэй болсноор Монголын хамгийн олон сүлжээ дэлгүүртэй компанийн байр сууриа хадгалсаар байгаа ба 12 аймагт СУ конвиниенс дэлгүүр үйл ажиллагаа явуулж, орон нутгийн хөгжлийг дэмжсээр байна. Компани нь нийт 73 дэлгүүрийг 65 жижиг дунд бизнес эрхлэгчдэд франчайзаар эзэмшүүлээд байна. Компани нь түргэн мууддаг хүнсний бүтээгдэхүүнийг тээвэрлэж буй ганц компани нь байна. Мөн шинэ хүнсийг хүргэснээр нийгэмд чухал нэмэр болж, Улаанбаатар хотын автомашины ачааллыг өдөрт 1,000 гаруй машинаар бууруулж байна. СУ нь Монголын хамгийн их үрийн кофе борлуулагч буюу өдөрт 21 мянган аяга кофе, Монголын хамгийн олон буюу өдөрт 94 мянган ширхэг хөргүүрийн болон халуун хоолоор үйлчилдэг сүлжээ дэлгүүр юм.

Компани нь дэлгүүрийн QSC буюу мэндчилгээ, үйлчилгээ, цэвэрлэгээнд нэн тэргүүнд анхааран ажилладаг. СУ нь Монголын хамгийн олон үнэнч хэрэглэгчтэй сүлжээ дэлгүүр бөгөөд нийт системийн борлуулалтын 41 хувийг СУ апп хэрэглэгч буюу үнэнч хэрэглэгч нарын худалдан авалт

эээлдэг. Хэрэглэгчид CU Pay төлбөрийн хэрэгслийг ашигласнаар оноо цуглуулах, төлбөр төлөх, цаасан eBarimt хэвлэн авах зэрэг дунджаар 30-45 секунд зарцуулдаг үйлчилгээг 3-5 секундийн дотор авах боломжтой болж, 10 дахин хурдтай үйлчлүүлэх боломжтой болсон бөгөөд CU Pay үйлчилгээг ашигласнаар жилд 1 тонн цаас хэмнэх болсон. Мөн CU апп ашиглан 300,000 хүртэлх хүүгүй, шимтгэлгүй зээлийн бүтээгдэхүүн авах боломжтой.

Охин компаниуд:

Сэнтрал Фүүдс ХХК нь Монголд MNS-ийн 5 стандартыг баталгаажуулсан анхны хоолны үйлдвэрийг ажиллуулдаг бөгөөд нийт сүлжээ дэлгүүрийн хоолны борлуулалтын 36 хувийг хангадаг. 2023 онд эрүүл ахуйн шаардлага хангасан 11.2 сая бэлэн бүтээгдэхүүн, 2024 онд 14.4 сая бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн. 38 мянган хэрэглэгчдээс авсан сэтгэл ханамжийн судалгаагаар хэрэглэгчийн сэтгэл ханамж 41 хувьтай гарсан бөгөөд олон улсад хэрэглэгчдийн 30-с дээш хувийн сэтгэл ханамжтай гарахыг маш сайн үзүүлэлт хэмээн үздэг.

Сэнтрал Коммерс ХХК нь Япон улсын Asahi пиво импортолдог, Asahi нь борлуулалтаараа импортын шар айргийн зах зээлийн 6.5 хувь, Монголын нийт шар айргийн зах зээлийн 2 хувийг эзэлж байгаа бөгөөд 2024 оны 5-р сараас эхлэн Asahi Super Dry пивыг 21 аймагт албан ёсоор борлуулж эхэлсэн. Тус компани нь 2024 оны 7-р сараас Чингис шар айргийн борлуулалт, түгээлт болон маркетингийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж эхэлсэн.

Сэнтрал Кофе Рөүстинг ХХК нь шинэ ургацын чанартай ногоон кофены үрийг гарал үүслээс нь импортлон оруулж ирж дэлхийн шилдэг Герман тохиологиор буюу Starbucks-ийн технологиор эх орондоо хуурч савлан борлуулдаг бөгөөд Монголын ногоон үр болон хуурсан үрийн кофены зах зээлийн 16 хувийг эзэлж байна. Мөн 2024 онд хуурсан кофег CU Get кофенд ашиглаж эхэлснээр Get кофены борлуулалт 32 хувиар өссөн байна.

Чингис Шар Айраг ХХК нь үйлдвэрлэлийн хүчин чадлаа 2.5 дахин нэмэгдүүлснээр жилд 2.5 сая литр шар айраг үйлдвэрлэх хүчин чадалд хүрсэн бөгөөд борлуулалтаараа Монголын шар айргийн зах зээлийн 1 хувийг эзэлж байна. Чингис шар айргийн 2 литрийн хэмжээтэй шинэ төрлийн савлагааг зах зээлд амжилттай нэвтрүүлэн CU салбаруудаар борлуулж эхэлсэн. Чингис Шар Айраг ХХК-ийг дахин үнэлүүлснээр 19.5 тэрбум төгрөгийн олз олсон бөгөөд ингэснээр компанийн нийт үнэлгээ 50 тэрбум төгрөгт хүрсэн.

Стора Централ ХХК нь stora.mn платформоор дамжуулан Amazon, Ikea, Apple, Taobao, Sephora дах барааг онлайнаар захиалан худалдан авах боломжийг олгодог бөгөөд 2024 онд Америкийн томоохон онлайн худалдааны платформ болох eBay платформ дээр борлуулагдаж буй 1.7 тэрбум гаруй бүтээгдэхүүн болон JD.com дээр байршиж буй хүнс бус өргөн хэрэглээний барааг онлайнаар худалдан авах боломжийг олгосон. Stora.mn нь Монгол Улсын и-коммерс онлайн худалдааны зах зээлийн 4 хувийг эзэлж байгаа ба 2024 оны 12-р сарын байдлаар 90 мянган бүртгэлтэй хэрэглэгчтэй болсон.

Премиум Нэксус ХК-ийн 2025 оны 1-р улирлын гүйцэтгэлээр дэлгүүрийн тоо Улаанбаатар хотод 397, орон нутагт 69, нийт 466 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 24 хувиар өссөн бөгөөд Баянхонгор, Дорнод аймгуудад шинэ салбар нээснээр үйл ажиллагаагаа 15 аймагт хүрээгээ тэлж байна. Мөн 2025 оны 1-р улиралд өмнөх оны мөн үетэй харьцуулахад Компанийн цэвэр борлуулалт 33 хувиар, харьцуулсан дэлгүүрийн гүйцэтгэлээр өдрийн дундаж борлуулалт 19.9 хувиар өссөн байна.

2024 онд Компани нь нийгмийн хариуцлагын хүрээнд өдөрт 1,500 гаруй хүнд үйлчлүүлдэг Шастины нэрэмжит 3-р эмнэлгийн ариун цэврийн өрөөг орчин үеийн эмнэлгийн шаардлага хангасан тоног төхөөрөмжөөр бүрэн шинэчилж, өвчтөнүүдийн тав тух, эрүүл ахуйн стандартыг хангасан цэвэр, цэмцгэр орчныг бүрдүүлж, хүлээлгэн өгсөн байна. Мөн Хөвсгөл аймгийг зорин ирэх жуулчид болон нутгийн иргэдэд олон улсын стандартчилагдсан үйлчилгээ хүргэхээр Улаанбаатараас 800 км-ийн зайд байрлах Мөрөн хотод 3 салбар дэлгүүрээ нээсэн.

Компани нь байгаль орчин, нийгэм, эдийн засагт бодитой эерэг хувь нэмэр оруулж, хувьцаа эзэмшигчдийнхээ итгэл найдварыг өндөрт хадгалж, салбартаа манлайлж ажиллахыг зорин ажилладаг. Энэ хүрээнд НҮБ-ын Тогтвортой хөгжлийн 17 зорилгод хувь нэмрээ оруулж байна. Тухайлбал Премиум Корпорэйшн, Премиум Нэксус хамтран Вэлүү сангийн хүүхдийн сайн сайхны төлөө хөтөлбөрийг 340 сая төгрөгийн хандиваар дэмжихээр болов. Нийслэлийн Цагдаагийн Удирдах Газартай хамтран ICU хөтөлбөрийг 2021 оноос хэрэгжүүлж эхэлснээс хойш гэрээсээ төөрсөн 14 хүүхдийг эцэг, эх, асран хамгаалагчид нь аюулгүй хүлээлгэн өгсөн бөгөөд Цагдаагийн Ерөнхий Газар болон GS25-тай хамтран 65 сая хүнд хүрсэн "Соёл танаас эхэлнэ" аян, насанд хүрээгүй хүүхдэд насны хязгаарлалттай бүтээгдэхүүн худалдан авахаас урьдчилан сэргийлж бичиг баримтыг шалгахыг уриалсан аяныг хэрэгжүүлсэн.

Санхүү хариуцсан захирал Г.Бат-Эрдэнэ 2024 оны санхүүгийн тайланг танилцуулав. Компанийн хөндлөнгийн аудитораар дэлхийн томоохон аудитын компаниудын нэг Кэй Пи Эм Жи Аудит ХХК 3 дах жилдээ ажиллаж байна.

Компанийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Партнер Жу Сан Ён-г танилцуулав. Компанийн үйл ажиллагааны цар хүрээ өргөжсөнтэй холбоотойгоор аудитын ажлыг туршлагатай ажлын хэсэг гүйцэтгэсэн бөгөөд нэмэлтээр мэдээллийн технологийн аудитын баг, үнэлгээний мэргэжилтнүүд, Солонгосын жижиглэн худалдааны салбарын аудит дээр ажилладаг чанарын аудитын партнер нар оролцсон.

Аудитаар Компанийн тусдаа болон нэгтгэсэн санхүүгийн тайланд хязгаарлалтгүй дүгнэлт өгсөн бөгөөд санхүүгийн тайлан нь СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудын дагуу үнэн зөв бодитой илэрхийлснийг; аудитыг Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэснийг; аудитын нотолгоо нь дүгнэлт өгөхөд хангалттай бөгөөд зохих үндэслэл болохыг; аудитын дүгнэлт гаргахад Компаниас хараат бус байж, Монгол Улс болон олон улс дах стандарт, зохицуулалтын хүрээнд ёс зүйн хариуцлагаа бүрэн биелүүлсэн болохыг; Компанийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хараат бус аудиторовн хувьд Компани болон охин компаниуд болох Сэнтрал Фүүдс ХХК, Чингис Шар Айраг ХХК, Сэнтрал Коммерс ХХК-д аудитын горимууд хийж гүйцэтгэснийг; нэгтгэсэн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт өгөхөд хангалттай нотлох баримт олж авсан хэмээн тус тус үзэж байгаа тухай дурдав.

Түүнчлэн аудитын горимоос гадна аудитын гол анхаарал зүйлс буюу 2024 онд Компанийн борлуулалтын орлогын хүлээн зөвшөөрөлт болон Чингис Шар Айраг ХХК, Сэнтрал Коммерс ХХК, Сэнтрал Кофе Рөүстинг ХХК, Стора Сэнтрал ХХК-ийг худалдан авсантай холбоотой материаллаг хэвийн бус гүйлгээнүүдэд илүү анхаарал хандуулан ажилласан бөгөөд борлуулалтын орлого хүлээн зөвшөөрөлтийг аудитын гол онцлох зүйлээр сонгосон байна. Түүнчлэн бизнес хурдацтай өргөжин тэлж, СУ дэлгүүрүүдийн тоо нэмэгдэн, 4 охин компани худалдан авсантай холбоотойгоор борлуулалтын орлого ихээр өссөн тул борлуулалтын орлогыг зохих нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу хүлээн зөвшөөрсөн эсэхийг шалган, удирдлага болон засаглах эрх бүхий этгээдүүдтэй ярилцлага хийн, зохих аудитын горимуудыг гүйцэтгэсэн. Эдгээр хийж гүйцэтгэсэн аудитын горимуудад үндэслэл, борлуулалтын орлого үнэн зөв илэрхийлэгдсэн гэж үзсэн.

Санхүү хариуцсан захирал Г.Бат-Эрдэнэ: Компанийн 2024 оны санхүүгийн харцаа үзүүлэлтийн хувьд борлуулалтын орлого 2023 онд 390.5 тэрбум төгрөг, 2024 онд 598.4 тэрбум төгрөг, нийт ашиг 23 тэрбум төгрөгөөс 110.5 тэрбум төгрөг болж өссөн. Хөрөнгийн өгөөж 2023 онд -15 хувь байсан бол 2024 онд 15.1 хувь, нийт ашгийн маржин 5 хувиас 18.5 хувь болж сайжирсан. Нийт ашиг сайжирсан нь нийт дэлгүүрийн тоо, нэгж дэлгүүрийн борлуулалт болон нэг дэлгүүрээр үйлчлүүлэх үйлчлүүлэгчдийн тоо өссөн, нэгж дэлгүүрийн зардлыг бууруулсантай холбоотой байсан. Үйл ажиллагааны зардлын хувьд 2024 онд өмнөх жилээс 114 хувиар өссөн, үүний 50-иас дээш хувь нь шинэ бизнесүүдийг нэгтгэсэнтэй холбоотой бөгөөд үлдсэн хувь нь Компанийн үндсэн үйл ажиллагааны тэлэлттэй холбоотой гарсан зардал байна. Хүү, татвар, элэгдэл хорогдлын өмнөх ашгийн хэмжээ 9.7 тэрбум төгрөгөөс 81 тэрбум төгрөг болж сайжирсан буюу 2.5 хувиас 13.5 хувь болж сайжирсан бөгөөд элэгдэл, хорогдлын зардал 32.8 тэрбум төгрөг, үүнд биет болон биет бус хөрөнгийн элэгдэл, хорогдол, түрээсийн хөрөнгийн хорогдол орсон. Мөнгө бус зардал 21 тэрбум төгрөг нь Чингис Шар Айраг ХХК-ийг Компанид нэгтгэснээр нэг удаагийн олз буюу 19.5 тэрбум төгрөгийн олз олсонтой холбоотойгоор өссөн. Компани нь 2024 онд 47.4 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай буюу 7.9 хувийн цэвэр ашгийн маржинтай байсан байна.

Компанийн бизнес нэгтгэлтэй холбоотой үнэлгээний ажлын талаарх мэдээллийг Эм Би Ви Си Үнэлгээ ХХК-ийн Зөвлөх үнэлгээчин Д.Баярсайхан танилцуулав. Тус үнэлгээний ажилд Чингис Шар Айраг ХХК, Чингис Шар Айраг Клуб ХХК, Стора Централ ХХК гэсэн 3 компанийн хөрөнгө болон өр төлбөрийг үнэлсэн бөгөөд баланс дээрх өр, төлбөрөөс гадна Чингис шар айраг брэндийн биет бус хөрөнгийг тодорхойлж, шинээр үнэлэн баланст тусгасан. Тус үнэлгээг гүйцэтгэхдээ Монгол Улсын Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, олон улсын хөрөнгийн үнэлгээний стандартууд, санхүүгийн тайлагналын олон улсын стандарт 3 буюу бизнесийн нэгдлийн стандарт гэсэн үндсэн 3-н хууль, дүрэм журмыг дагаж мөрдсөн. Үнэлгээний аргачлалын хувьд 3-н үндсэн аргачлалыг ашигласан, үүнд өртгийн хандлага, зах зээлийн хандлага, орлогын хандлага. Орлогын хандлагыг олон үет илүүдэл ашгийн аргыг ашиглан шинээр тодорхойлсон биет бус хөрөнгө буюу Чингис шар айраг брэндийг үнэлэхэд ашигласан. Үнэлгээг гүйцэтгэхээс өмнө Чингис шар айргийн бизнес 5.9 тэрбум төгрөг байсан бол үнэлгээг гүйцэтгэсний дараа 50.3 тэрбум төгрөг болж өссөн, үүнд голчлон Чингис шар айраг брэндийн үнэлгээ буюу 32.2 тэрбум төгрөг нэмэгдэж орж ирсэнтэй холбоотой байна. Стора Централ ХХК-ийн үнэлгээг оруулаад бизнесийн нэгдлийн нийт үнэлгээ нь 51.9 тэрбум төгрөг болж өссөн байна.

Санхүү хариуцсан захирал Г.Бат-Эрдэнэ – Чингис Шар Айраг ХХК-ийг хөндлөнгийн байгууллагаар үнэлсэн үнэлгээний дагуу 2024 оны тайланд нэг удаагийн 19.5 тэрбум төгрөгийн олзыг тусгасан байна.

Компанийн 2024 оны нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангийн хувьд 2023 оноос 120 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 313.9 тэрбум төгрөг болсон ба 120 тэрбум төгрөгийн 38 нь эргэлтийн хөрөнгө, 82 нь эргэлтийн бус хөрөнгө байна. Эргэлтийн хөрөнгө өссөн шалтгаан нь бараа материал өссөнтэй холбоотой бөгөөд бараа материал нь дэлгүүрийн тэлэлттэй холбоотойгоор өссөн байна. Эргэлтийн бус хөрөнгийн хувьд биет болон биет бус хөрөнгө 2023 онд 90.2 тэрбум төгрөг байснаас 157.9 тэрбум төгрөг болж өссөн. Энэхүү өсөлт нь дэлгүүрийн тэлэлттэй холбоотой биет хөрөнгө оруулалт болон Чингис Шар Айраг ХХК-ийн үнэлгээтэй холбоотой биет бус хөрөнгө буюу брэндийн үнэлгээ байна. Компанийн өр төлбөрийн хувьд гол анхаарч харах асуудал нь дансны өглөг байгаа ба Компани нь 2024 оноос өглөгийг хугацаанд нь төлдөг болсон. Урт хугацаат өглөгийн буюу банкны зээлийн хувьд Компани нь 50 орчим тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй, үүнээс богино хугацаат зээл 25 тэрбум төгрөг, урт хугацаат зээл 24 тэрбум төгрөг байна. Компани нь зээлийг дотоодын эх үүсвэрээс авсан ба 2025 оноос гаднын урт хугацаатай, хүү багатай зээлийн эх үүсвэрийг оруулж ирэхээр ажиллаж байна. Эздийн өмч 2023 онд -14.2 тэрбум төгрөг байсан буюу Компани 2023 оны эцэс хүртэл алдагдалтай ажилласан хэдийн ч 2024 онд хөрөнгө оруулагчийн зүгээс биет хөрөнгө

болон бэлэн мөнгөөр хөрөнгө оруулалт хийсэн, мөн Компани ашигтай ажилласан тул эздийн өмч 102.8 тэрбум төгрөг болж өссөн.

Компанийн 2024 оны нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан: үйл ажиллагаанаас 50.5 тэрбум төгрөг сулласнаас 38.3 тэрбум төгрөгийг дэлгүүрийн тэлэлт, түгээлтийн төв, мэдээллийн технологийн хөрөнгө оруулалтад зарцуулсан байна. Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний хувьд Компани нь 2024 онд 13.4 тэрбум төгрөгийн зээлийн төлөлт, санхүүгийн түрээсийн өр төлбөрийг бууруулсан. 2024 онд эцэст цэвэр мөнгөн гүйлгээгээр 7.5 тэрбум төгрөгийн эерэг үр дүнтэй гарсан.

Компанийн 2024 оны өмчийн өөрчлөлтийн тайлан: 60 тэрбум төгрөгийн хувьцааг нэмж гарган, 47.4 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласнаар 2024 оны жилийн эцэст эздийн өмч 102.8 тэрбум төгрөг болсон байна.

Компанийн 2024 оны хувьцааны хөдөлгөөн: 2024 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар Компанийн зах зээлийн үнэлгээ 232 тэрбум төгрөг байсан ба МХБ-ийн зах зээлийн үнэлгээгээр 11-р байрт эрэмбэлэгдэж, нийт зах зээлийн 1.79 хувийг бүрдүүлж байна. Компанийн MSE: CUMN хувьцаа нь 2024 онд МХБ-ийн хувьцааны арилжааны үнийн дүнгийн эрэмбээр 9-д, арилжаалагдсан тоо ширхгийн эрэмбээр 4-т тус тус жагссан. 2024 оны байдлаар МХБ-ийн хоёрдогч зах зээлийн хувьцааны арилжааны үнийн дүнгийн 3.1 хувийг эзэлж байсан байна.

Асуулт: С.Ерөөлт – СЮ хамт олонд талархал илэрхийлэв. Франчайз эрх олгосон дэлгүүрийн нийт дэлгүүрт эзлэх хувь нь 16 байна, энэ тоог цаашид барих эсэх, 500 дэлгүүрийн хүний нөөцийн бодлого, үүнд технологийн шийдэл олох эсэх, бараа бүтээгдэхүүний хэдэн хувийг өөрсдөө хийдэг, нийлүүлэгчдийн тооны харьцааг бууруулах эсэх, Голомт зээлийн картын эрсдэлийг хэн хариуцаж байгаа вэ?

Хариулт: Гүйцэтгэх захирлын орлогч Г.Чинзориг – Файнчайз эрх эзэмшигчдийн тоог нэмэх хүсэл байгаа хэдий ч зах зээлийн нөхцөл байдлаас шалтгаалан франчайз эрх олгох тодорхой тоо гаргаагүй байна. Хүний нөөцийн хувьд бид тогтолцоог өөрчилсөн, тогтвортой ажиллуулах бодлого баримталж тасралтгүй, удаан ажилласны урамшуулах систем руу шилжсэн. Монгол Улсын хувьд насны суваргаар ажиллах хүч, залуучууд нэмэгдэж байгаа. Мөн бүтээмжийг өсгөх нь чухал байдаг, бид технологийн дэвшлийг ашиглан автомат захиалгын системийг нэвтрүүлснээр дэлгүүрийн менежерийн ажлын 1 цагийг хэмнэж чадсан. Компанийн хувьд 300 нийлүүлэгчтэй, дэлгүүрт борлуулагдаж байгаа нийт бараа бүтээгдэхүүний 30 хувийг нийлүүлдэг, нийт 21 хоол үйлдвэрлэгч байгаа ба үүний нэг нь Сэнтрал Фүүдс ХХК, бид хамтдаа хөгжиж байна. Голомт зээлийн хувьд эрсдэлийн сан үүсгээд явж байгаа ба эрсдэлийг эхлээд Голомт хариуцна.

Асуулт: Б.Ганболд – Тэлэлт хурдацтай явж байна, алслагдмал аймагт түргэн муудах бүтээгдэхүүний чанарын асуудлыг хэрхэн шийдсэн бэ, брэндийн нэр хүндэд сөргөөр нөлөөлөх асуудал гарах эсэх, ямар стандарт байна вэ?

Хариулт: Гүйцэтгэх захирлын орлогч Г.Чинзориг – Компанийн зүгээс хурд болон тээвэрлэлтийн горим дээр хяналт тавьдаг, 30 минут тутамд хөргүүрийг шалгадаг бөгөөд бэлэн хоолны битүүмжийг алдагдуулахгүй байх технологид хөрөнгө оруулалт хийсэн. Хүргэлтийг 800 км-т хийж байна.

Асуулт: Бямбадорж – Урт, богино хугацааны өр төлбөрийн хувьд зээлийн хүүгийн зардал байгаа байх. Өртөг буурахгүй байна, 60 тэрбум төгрөгийн өрийг ирээдүйд хэрхэн бууралт вэ?

Хариулт: Санхүү хариуцсан захирал Г.Бат-Эрдэнэ – Зээлийн үлдэгдэл 50 тэрбум төгрөг байна, Компани тэлэлт хийж байгаатай холбоотой зээлийг жил бүр төлөөд шинээр зээл авдаг, ойрын хугацаанд 100 дэлгүүр шинээр нээх төлөвлөгөөтэй уялдуулаад өр төлбөр өснө. Бид өртгийг бууруулах, бага хүүтэй зээл авах, гаднын зээл авах зэрэг арга хэмжээ авч байна.

3. КОМПАНИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТУЗ-ИЙН ГАРГАСАН ДҮГНЭЛТИЙГ БАТЛАХ

ТУЗ нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 болон Компанийн Дүрмийн 9.4.9-р заалтыг тус тус үндэслэн Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд дараах дүгнэлтийг гаргаж, хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулав.

Компани нь 2024 онд 81 салбар дэлгүүрийг нээж, мэдээлэл технологийн системээ сайжруулж, түгээлтийн дэд бүтцээ олон улсын стандартын шаардлагад нийцүүлж нийт бүтээгдэхүүнийхээ 99 хувийг өөрийн түгээлтийн сүлжээгээр дамжуулан хэрэглэгчдэд очих эцсийн үйлчилгээний чанараа дэлхийн жишигт хүргэх нөхцөлийг бүрдүүлсэн бөгөөд орон нутгийн 12 аймагт 49 салбар дэлгүүр ажиллуулж, хүнсний хангамж, ариун цэврийн хүртээмжийг нэмэгдүүлж, ажлын байр бий болгосноор дотоодын аялал жуулчлалд чухал нөлөө үзүүлсэн.

Мөн бизнесийн дэд бүтцээ өргөтгөн тэлж, үйл ажиллагааны стандарт, хүний нөөцийн чадавхыг сайжруулснаар урт хугацааны өрсөлдөх чадвараа улам бүр бэхжүүлж, үйл ажиллагааны бүх шатанд байгаль орчин, нийгэм, засаглалын суурь үнэлгээг хийлгэсэн бөгөөд НҮБ-ийн тогтвортой хөгжлийн баримт бичгийн хүрээнд гарсан ядуурал, тэгш бус байдал, уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтол, энх тайван, шударга ёс зэрэг 17 зорилгоос 15 зорилгыг биелүүлж нийгэмд хувь нэмрээ оруулж ажилласан байна.

2024 онд Компани нь анх удаа 28 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны цэвэр ашигтай ажиллаж, Чингис Шар Айраг ХХК-ийн бизнесийн нэгтгэлээс 19.5 тэрбум төгрөгийн нэмэлт ашиг олсноор нийт цэвэр ашиг 47.4 тэрбум төгрөгт хүрсэн. Иймд Компанийн Гүйцэтгэх удирдлагын баг 2024 онд төлөвлөсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн ашиглан ажилласан хэмээн ТУЗ дүгнэв.

4. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХГҮЙ ТУХАЙ ТУЗ-ИЙН ШИЙДВЭР, ТҮҮНИЙ ШАЛТГААН

Компанийн тухай хуулийн 47.1 дэх заалтыг үндэслэн ТУЗ нь Компанийн 2024 оны санхүүгийн жилийн цэвэр ашиг (алдагдал)-аас ногдол ашиг хуваарилахгүй байхаар ТУЗ шийдвэрлэснийг хуралд танилцуулав.

Асуулт: Б.Баасандорж – Ногдол ашгийн талаарх мэдээлэл өгнө үү, 2025 онд ногдол ашиг тараах уу, хэдэн оноос эхэлж ногдол ашиг тараах вэ?

Хариулт: Санхүү хариуцсан захирал Г.Бат-Эрдэнэ – Компанийн тухай хуулийн 47 дугаар зүйл заалтын дагуу Компани нь 2025 онд ногдол ашиг тараах нөхцөл бүрдэхгүй, хуулийн дагуу ногдол ашиг тараах нөхцөл бүрдсэн буюу ашигт ажиллагаанд хүрсний дараа үүнд хариу өгөх боломжтой. Цаашид мэдээллээр хангаад явах болно.

Гүйцэтгэх захирал А.Ганхуяг – Ногдол ашиг бол хувьцаа эзэмшигчид өгөөж өө хүртэх боломжтой болох чухал асуудал. Компани нь 2023 онд 117 тэрбум төгрөгийн хуримтлагдсан алдагдалтай байсан бол энэ нь 2024 онд 60 тэрбум төгрөг болж буурсан. 2025 онд ашигт ажиллагаа өндөр байх төлөвтэй байгаа ба 2025-2026 онуудад дэлгүүрийн тэлэлт хийх зах зээлийн боломж байгаа тул

тэлэлт хийх, 2027-2028 онд зах зээл ханаж, дэлгүүрийн тэлэлтийн хурд саарах тул бэлэн мөнгөний хуримтлал нэмэгдэх төлөвтэй байна.

5. ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙГ ДАХИН ТОМИЛОХ

ТУЗ-ийн ердийн гишүүн Залаа-Уулын Уянга-г ТУЗ-ийн 2024 оны 11-р сарын 07-ны өдрөөр чөлөөлж, түүний оронд Чойжин-Осорын Мөнхчимэгийг ТУЗ-ийн ердийн гишүүнээр түр томилсонтой холбогдуулан Компанийн тухай хуулийн холбогдох заалтуудыг үндэслэн ТУЗ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгож шинэ бүрэлдэхүүнээр буюу Адилбишийн Ганхуяг, Адилбишийн Ганболд, Гансүхийн Бат-Эрдэнэ, Чойжин-Осорын Мөнхчимэг, Болдбаатарын Бат-Эрдэнэ, Ганболдын Чинзориг нарыг ТУЗ-ийн ердийн гишүүнд, Гари Стивен Биондо, Өлзийсүрэнгийн Эрдэнэчимэг, Ванчигийн Ганзориг нарыг ТУЗ-ийн хараат бус гишүүнд тус тус нэр дэвшүүлж сонгуулахаар санал болгож байгаа тухай дурдаад ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн видео танилцуулга хийв.

6. САНАЛ ХУРААЛТ, ХУРЛААС ГАРАХ ШИЙДВЭР

Хуралд санал өгөх видео зааврыг дэлгэцээр танилцуулав. Хурал зохион байгуулах комиссын дарга санал хураалтыг эхлүүлэв.

Хурал зохион байгуулах комиссын дарга Тооллогын комиссыг Хурлын санал хураалтын дүнг танилцуулахыг хүсэв. Тооллогын комиссын дарга Хурлын санал хураалтын дүнг дараах байдлаар Хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчдэд мэдээлэв. Үүнд:

- 1. **Компанийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах:** зөвшөөрсөн 1,017,210,370 ширхэг хувьцаа буюу 91.3 хувь, татгалзсан 12,224 ширхэг хувьцаа буюу 0.001 хувь, түдгэлзсэн 0 ширхэг хувьцаа буюу 0 хувь байна.
- 2. **Компанийн ТУЗ-ийн гишүүдийг томилох:** Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгуулахаар нэр дэвшсэн хүн тус бүрээр кумулятив аргаар өгсөн саналын тоо:

№	ТУЗ-ийн гишүүд	Саналын тоо	Саналын хувь
Ердийн гишүүд			
1	Адилбишийн Ганхуяг	1,017,292,152	11.11 %
2	Адилбишийн Ганболд	1,017,256,424	11.11 %
3	Гансүхийн Бат-Эрдэнэ	1,017,186,619	11.11 %
4	Чожин-Осорын Мөнхчимэг	1,017,185,429	11.11 %
5	Болдбаатарын Бат-Эрдэнэ	1,017,249,617	11.11 %
6	Ганболдын Чинзориг	1,017,192,350	11.11 %
Хараат бус гишүүд			
1	Өлзийсүрэнгийн Эрдэнэчимэг	1,017,275,388	11.11 %
2	Ванчигийн Ганзориг	1,017,198,448	11.11 %
3	Гари Стивен Биондо (Gary Stephen Biondo)	1,017,167,019	11.11 %

Хурлын дарга санал хураалтын дүнтэй танилцаад хурлаас дараах шийдвэрүүд гарсан тухай танилцуулав. Үүнд:

Тогтоол 1: Компанийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах:

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт, Премиум Нэксус ХК ("Компани")-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04-р сарын 29-ний өдрийн ээлжит хурал ("Хурал")-ын шийдвэр, Хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хавсралт ёсоор баталсугай.

Тогтоол 2: Компанийн ТУЗ-ийн гишүүдийг томилох:

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дох заалт, 77 дугаар зүйлийн 77.3, 77.4 дэх заалт, Премиум Нэксус ХК ("Компани")-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04-р сарын 29-ний өдрийн ээлжит хурал ("Хурал")-ын шийдвэр, Хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн ердийн гишүүдээр дор дурдсан нэр бүхий хүмүүсийг томилсугай. Үүнд:
 - (i) Адилбишийн Ганхуяг,
 - (ii) Адилбишийн Ганболд,
 - (iii) Гансүхийн Бат-Эрдэнэ,
 - (iv) Чойжин-Осорын Мөнхчимэг,
 - (v) Болдбаатарын Бат-Эрдэнэ,
 - (vi) Ганболдын Чинзориг.
2. Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүдээр дор дурдсан нэр бүхий хүмүүсийг томилсугай. Үүнд:
 - (i) Гари Стивен Биондо (Gary Stephen Biondo),
 - (ii) Өлзийсүрэнгийн Эрдэнэчимэг,
 - (iii) Ванчигийн Ганзориг.
3. Компанийн ТУЗ-ийн гишүүдийг Хуулийн этгээдийн бүртгэлийн газар болон бусад холбогдох байгууллагад бүртгүүлэх зэрэг дээрх шийдвэрийг бүрэн гүйцэд хэрэгжүүлэхэд шаардлагатай буюу зүйтэй хэмээн үзсэн бүх арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал (А.Ганхуяг)-д үүрэг болгосугай.

7. ХУРЛЫН ХААЛТ

Ийнхүү хэлэлцэх асуудал дууссан тул Хурлын дарга Хуралд цаг гарган хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчид болон Хурал зохион байгуулсан комисст талархал илэрхийлэв. Монгол Улсад цоо шинэ бизнесийг хамтдаа цогцлоож нийт хэрэглэгчид дээ таниулж, ганц Улаанбаатар хот бус орон нутагт түгээж байна. Бидний бизнес үр хүүхдүүд дээ үлдээх том хөрөнгө оруулалт болно гэж найдаж байгаагаа илэрхийлээд хурлыг хаав.

ХУРЛЫН ДАРГА

